



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/35

Шивээговь сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2023 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Хогны машин худалдан авах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог зөвшилцсөнөөр дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

О.Отгонбаяр

(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Ч.Басбайгаль

(Эрүүл мэндийн төвийн жор баригч)

Б.Цогт-Эрдэнэ

(Шивээ Овоо хувьцаат компанийн Хяналтын мэргэжилтэн)

Ц.Эрдэнэбат

(Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга:

Б.Алтансүх

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.“Хогны машин худалдан авах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу хариуцлагатай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (О.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ